



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 46 (475)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2007 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай*
- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2006 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны арванхоёрдугаар сарын 15

№46 (475)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 670. | Төрөөс мөнгөний бодлогын талаар 2007 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай     | Дугаар 86 | 1317 |
| 671. | Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай. | Дугаар 87 | 1318 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 672. | Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай. | Дугаар 48 | 1326 |
|------|---|-----------|------|

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

### Төрөөс мөнгөний бодлогын талаар 2007 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2007 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /А.Батсүх/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ЦНЯМДОРЖ**

Улсын Их Хурлын 2006 оны  
86 дугаар тогтоолын хавсралт

### ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2007 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрөөс 2007 онд баримтлах мөнгөний бодлого нь инфляцийг бага түвшинд байлгах, санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэхэд чиглэх ба энэ талаар Монголбанк дор дурдсан бодлогыг хэрэгжүүлнэ:

Нэг.Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийг жилийн 5 хувиас хэтрүүлэхгүй ба үүний тулд:

1.1.нийт мөнгөний жилийн өсөлтийг эдийн засгийн өсөлттэй уялдуулна;

1.2.нөөц мөнгөний бодлогын хэлбэрээс инфляцийг онилох мөнгөний бодлогын шинэ загварт шилжих ажлыг эхлүүлнэ;

1.3.заавал байлгах нөөцийн хувь, Төв банкны үнэт цаасны хүү, хямдруулалтын хувийг уян хатан тогтооно;

1.4.банкуудын ашигт ажиллагааны болон зээл, хадгаламжийн хүүгийн түвшинд судалгаа хийнэ;

1.5.мөнгөний нийлүүлэлтийн статистик судалгаа, мэдээллийн хамралт /хадгаламж, зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаас, санхүүгийн түрээс гэх мэт/-ыг холбогдох байгууллагатай хамтран боловсронгуй болгох замаар зээлийн хүүгийн нэгдсэн бодлого явуулах эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авна.

Хоёр.Банкны салбарын санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэн санхүүгийн бүтээгдэхүүний хэлцлийн хугацааг уртасгах ба үүний тулд:

2.1.бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор

Монголбанкны дэргэдэх Банк хоорондын төлбөр тооцооны төвийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ;

2.2. жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зориулалт бүхий гадаад зээлийн дамжуулан зээлдүүлэх хүүг бууруулах, хугацааг нь уртасгах боломжийг Засгийн газартай хамтран судалж шийдвэрлэн хэрэгжилтийг илүү нээлттэй болгоно;

2.3. гадаад зах зээлээс урт хугацаатай санхүүгийн эх үүсвэр татах замаар хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх ажлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ;

2.4. үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан урт хугацаатай, бага хүүтэй 200 сая ам.долларын зээлийг гадаад зах зээлээс нийлүүлэх ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулна;

2.5. Монголын Ипотекийн Корпораци /МИК/-ийн үйл ажиллагааг эхлүүлэх эрх зүйн орчны үнэлгээг хийж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлийг ажиллуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Гурав. Арилжааны банкуудын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг олон улсын жишигт бүрэн нийцүүлж, санхүүгийн зах зээлд нэгдсэн хяналт тавих эрх зүйн зохицуулалт нэвтрүүлэх ба үүний тулд:

3.1. эрсдэлийн удирдлагад чиглэсэн хяналт шалгалтын заавар, журмыг боловсронгуй болгоно;

3.2. өмчийн болон ашиг сонирхлын хувьд харилцан хамаарал бүхий банк, санхүүгийн

байгууллагуудыг нэгдсэн удирдамжаар хянан шалгах санал боловсруулж эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ;

3.3. санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааг нь идэвхжүүлж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

Дөрөв. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахын тулд бодлогын чанартай дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1. төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн чөлөөт тогтолцоог үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ;

4.2. гадаад валютын цэвэр албан нөөцийг 620 сая ам.доллар буюу импортын 18 долоо хоногийн хэрэгцээнээс багагүй түвшинд байлгана.

Тав. Банкны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

5.1. хадгаламжийн даатгалын эрх зүйн үндсийг бүрдүүлнэ;

5.2. Монголбанкны удирдлагын зохистой арга хэлбэрийг боловсронгуй болгох, арилжааны банкуудад тавих хяналтыг сайжруулах, өрсөлдөөн, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих чиглэлээр Төв банкны тухай болон Банкны тухай хуулиудыг боловсронгуй болгоно;

5.3. Монголбанк иргэний эрх зүйн харилцаанд оролцох эрх зүйн орчныг бий болгож, ил тод байдлыг хангана.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

### Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг Улсын Их Хурлаас баталсан бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан, Монгол Улсын 2007 оны төсвийн хуулийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч нарыг санхүүжилтийн эх үүсвэрээр хангаж, цаг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газар /М.Энхболд/, Монголбанк /А.Батсүх/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагын удирдлагад даалгасугай.

3. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, түүнийг зохицуулах үйл ажиллагааны уялдааг хангаж ажиллахыг Засгийн газар /М.Энхболд/, Монголбанк /А.Батсүх/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд үүрэг болгосугай.

4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд төсвийн бус эх үүсвэрийг дайчилж ажиллахыг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай.

5. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн явцын талаар 2007 оны 10 дугаар сард, хэрэгжилтийг 2008 оны 1 дүгээр улиралд багтаан тус тус Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

Улсын Их Хурлын 2006 оны 87 дугаар  
 тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2007 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Д/д | Зорилт, арга хэмжээ<br>2   | Хэмжих шагуур, үзүүлэлт<br>3  | 2007 оны<br>түвшин<br>4 |
|-----|--|---|-------------------------|
| 1   | <b>Нэг. Макро эдийн засаг</b>  |   |                         |
| 1   | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийн хурдныг нэмэгдүүлэх  | ДНБ-ий өсөлт / хувиар/<br>хэрэглээний үнийн индекс / хувиар/  | 8.6                     |
| 2   | Инфляцийн түвшнийг макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах түвшинд барих бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх  | импортын хэрэгцээг хангах доод хэмжээ / 1.7 хонот /   | 5.0                     |
| 3   | Гаднац валютын цөөрөр албан нөөцийг нэмэгдүүлэх  | ДНБ-д гадаад ерийн зээлх дээд хязгаар / хувиар/   | 18                      |
| 4   | Гадаад, дотоод ерийн тогтвортой байдлыг хангах, ерийг Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүй байхавар зохиистой удирдах                    | ДНБ-д экспортын зээлх хувь  | 62.0                    |
| 5   | Экспортод гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан, хэмжээг нэмэгдүүлэх   | ДНБ-д гадаад худалдааны алдагдлын зээлх дээд хязгаар / хувиар/  | 60.0                    |
| 6   | Гадаад худалдааны алдагдлыг бууруулах  | ДНБ-д жоренгийн зардлын зээлх хувь<br>- ДНБ-д гадаадын шууд жоренго оруулалтын зээлх хувь<br>жоренго оруулалтын төлөвлөгөөний биелэлт / хувиар/ | -1.0                    |
| 7   | Гадаад, дотоодын жоренго оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх  | Гадаад зээлийн ашиглалтын доод хэмжээ / хувиар/   | 6.7                     |
| 8   | Төслийн жоренго оруулалтыг хугацаанд нь бүрэн санхүүжүүлэх   | нийт орлогод татварын бус орлогын зээлх хувь  | 4.3                     |
| 9   | Гадаадын зээлийн ашиглалтыг сайжруулах   | ДНБ-д төслийн алдагдлын зээлх дээд хязгаар / хувиар/  | 100.0                   |
| 10  | Татварын авчлалтыг багасгах, татвар төлөх хүрээг өргөжүүлэх, гааль, татварын байгууллагын ил тод байдлыг хангах  | сангийн бүрдүүлэлтээр судалгааны тайлан гаргах хугацаа үйл ажиллагааны хэрэгжилтээр   | 90.0                    |
| 11  | Төслийн тогтвортой байдлыг хангах, төслийн зарлагын шигшчлэлийг хэрэгжүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  | 16.0                    |
| 12  | "Монгол Улсыг хөгжүүлэх сан"д жоренго төвлөрүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  | -3.9                    |
| 13  | Бодит эдийн засгийн байдалд нарийвчилсэн судалгаа, үнэлгээ хийх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                         |
| 14  | Жоренгийн биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлыг жолбодох байгууллагууд хамтарч зохион байгуулах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр  | IV улирал               |
| 15  | Үл хөдлөх эд жоренгоор баталгаажсан үнэт цааны зах зээлийг идэрхжүүлэх, орон сууцаар барьцаалсан үнэт цааны зах зээлийг хөгжүүлэх бодлогыг төрөөс дэмжих | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                         |
| 16  | Хөдлөх, үл хөдлөх эд жоренгийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох   | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                         |
| 17  | <b>Хоёр. Бодит салбарын бодлого</b>  |   |                         |
|     | Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, боловсруулах салбарын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх  | аж үйлдвэрийн салбарын өсөлт / хувиар/  | 11.1                    |

|    |   |   |                             |
|----|---|---|-----------------------------|
| 18 | Аж үйлдвэрийн парк байгуулах ажлыг эхлэх  | хөтөлбөрийн хэрэгжилтээр  |                             |
| 19 | Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажлыг идэвхижүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 20 | Цагааннуурын худалдааны чөлөөт бүсийн хамгаалалтын байгууламжийг барьж, үйл ажиллагааг нь хэсэгчлэн эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  | 11.5                        |
| 21 | "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөр хэрэгжүүлэх  | уул уурхайн салбарын өсөлт /хувиар/   |                             |
| 22 | Уул уурхайн салбарын өсөлтийг хангах боломжийг дээшлүүлж, шинэ орд эзэмших ажлыг эрчимжүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 23 | Стратегийн ач холбогдол бүхий орд газруудын жорсаалтыг баталж, үйл ажиллагааны нь чиглэлийг тогтоох замаар ашиглалтын зохистой бодлого хэрэгжүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 24 | Оюу толгойн ордууд хөрөнгө оруулагч компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 25 | Төрийн толгойн ордыг ашиглах талаар яриа хэлэлцээр хийж, ашиглалтын өмнөх бэлтгэлийг хангуулах  | хөдөө аж ахуйн салбарын өсөлт /хувиар/<br>- гурилаар хангах доод хязгаар /хувиар/<br>- төмсөөр хангах доод хязгаар /хувиар/<br>- хүнсний ногоогоор хангах доод хязгаар /хувиар/ | 4.5<br>42.0<br>80.0<br>50.0 |
| 26 | Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр  | 22                          |
| 27 | Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, дотоодын хүнсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хангамжийн нэмэгдүүлэх   | усалгаатай нөхцөлд тариалах тариалангийн талбай /ман га/  | 1830                        |
| 28 | Хүн ам төвлөрсөн томоохон төв, суурин газар, бүсийн тулгуур төв хотуудын орчимд эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг хөгжүүлэх   | Бага өврийн техникээр хангагдах өрх, аж ахуйн нэгжийн тоо   | 3635                        |
| 29 | Усалгаатай тариаланг хөгжүүлэх, газар тариалангийн салбарт техник, технологийн шинэчлэл хийж  | ашиглалтад орох 10, 15, 35 квт шугамын урт, км  |                             |
| 30 | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх бага өврийн техникийн хангамжийг нэмэгдүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 31 | Цахилгаан, эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  | 55                          |
| 32 | ТЭЦ-У станцйн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах  | II хагаст   |                             |
| 33 | Оюу толгойн чиглэлд 220 киловольтын цахилгаан дамжуулах шугам барьж эхлэх   | Сумдын тоо  |                             |
| 34 | Сумдын төвийг эрчим хүчний төвлөрсөн, найдвартай системд холбох   | ашиглалтад оруулах хугацаа  |                             |
| 35 | Дөрлөн, Тайширын УЦС-ыг ашиглалтад оруулж, баруун таван аймгийг эрчим хүчээр хангах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр  | 75000                       |
| 36 | Эрдэнэбүрэн сумын УЦС-ын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах  | малчин өрх тоо  | 5.0                         |
| 37 | Эдийн голын усон цахилгаан станцыг барих ажлыг эхлүүлэх   | төмөр замын ачаа тээврийн өсөлтийн доод хязгаар /хувиар/  |                             |
| 38 | Малчин өрхийг сэргээгд эрчим хүчээр хангах ажлыг эрчимжүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 39 | Төмөр замын сулраж эргэтгөж, тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх иж бүрэн төлөвлөгөө боловсруулж, замын техникийн шинэчлэл хийх ажлыг үргэлжлүүлэх, төмөр замыг цахилгаанжуулах судалгаа хийх | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 40 | Нийслэлд байгуулах олон улсын шинэ чанартай вокзалын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 41 | Шинээр авто зам барих, засварлах, шинэчлэхэд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |
| 42 | Мөнгөний замын хэвтээ тэнгэлийн баруун, зүүн чиглэлийн зам барих ажлыг эрчимжүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |                             |

|    |   |   |          |
|----|---|---|----------|
| 43 | Хархорин-Цэцэрлэг-Цагаандавад-Солонгот-Тосонцэнгэл, Арвайхээр-Баянхонгор-Говь-Алтай-Ховд, Манхан-Уенч чиглэлийн хайрган хучилттай замыг хатуу хучилттай болгож ажлыг эхлүүлэх, Дашинчилэн-Орхон-Хашеөцайдан, Улаанбаатар-Лун-Эрдэнэсант, Булган-Увчт, Говьсүмбэр-Сайншид-Замын-Үүд, Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн хатуу хучилттай замыг барьж, босоо тэнхлэгийн Ярант-Ховд-Цагааннуур чиглэлийн автозамыг барих ажлыг эргэлжлүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 44 | Улаанбаатар-Мандалговь-Далонзадгад-Тэвэнголгой-Оюутолгой-Гашуунсүхэйт, Ховд-Улиастай чиглэлийн замын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 45 | Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Ховдан голд барих төмөр бетон гуурийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 46 | Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Хархорин, Увс аймгийн нисэх онгоцны буудлыг хатуу хучилттай болгож ажлын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 47 | Нийслэлийн авто замыг бүрэн хэмжээгээр засч шинэчлэх ажлыг эхлүүлэх   | хотын нийт замд шинэчилсэн авто замын эзлэх хувь  | 15.0     |
| 48 | Систем хэмжээнд нэгдмэл кодчллыг бий болгон мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 49 | "40000 орон сууц хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх   | ашиглалтад шинээр орох сууцны тоо   | 9.300    |
| 50 | Хүн амыг орон сууцар хангах хөтөлбөрийн хүрээнд цагингараа орон сууцтай болох төслийг дэмжих дэс даралттай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх замаар орон сууцны салүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох   | Орон сууцны урт хугацаат эзэлд хамрагдах иргэдийн тоо   | 20000    |
| 51 | Улаанбаатар хотын гэр хорооллын автозам, дулаан, цахилгаан, усан хангамжийг сайжруулах, шинээр барих  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 52 | ТЭЦ-4-өөс Яармаг, Найрамдал зуслан хүртэл дулааны шугам барих   | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 53 | Дархан хотын дулааны станцын гаднах шугамыг шинэчилж дуусгах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  | 2007 онд |
| 54 | Орхон аймгийн Баян-Өндөр сум /Эрдэнэт хот-ын инженерийн шугам суулгаж шинэчлэх ажлыг эхлүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 55 | "Орхон аймгийн цэвэр усны хангамжийг сайжруулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 56 | Эдийн засагт хувийн салбарын эзлэх бэйр, суурийг бэхжүүлэх бодлого баримтлах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 57 | Гэр хороололд утаа багатай хатуу, шингэн, хийн түлш хэрэглэх хүрээг өргөжүүлэх  | <b>Гурав Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого</b><br>үйл ажиллагааны хэрэгжилтээр |          |
| 58 | Улаанбаатар хотыг утаагүй болгох төслийг хэрэгжүүлэх, агаарын цагийн ялгавартай тоолуурын хэмжээг нэмэгдүүлэх   | цагийн ялгавартай тоолуурын хэмжээ /хувиар/   | 25.0     |
| 59 | "Эрдэнэт" үйлдвэрийн хаягдал, цагаан тоосны дэгдэлтийг хүрээлэн байгаа орчин, хүн, мэлд аюулгүй болгох түвшинд хүртэл бууруулах зорилго бүхий хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 60 | Говийг цогцлоогоороо хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, говь болон Төв-Дархан-Сэлэнгийн эдийн засгийн бүс байгуулах бэлтгэл хангах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |
| 61 | Говь, хээрийн бүсийн бэлчээрийн ургацон гарцыг нэмэгдүүлэх, цөлжилтөөс хамгаалах ажлыг сайжруулах зорилгоор механик аргаар бороо оруулах нөхцөлийг бүрдүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр  |          |

|    |   |  |              |
|----|---|--|--------------|
| 62 | Төвийн болон зүүн бүсийн аймгуудын нийтийн аж ахуйн үйлчилгээг хөгжүүлэх барилгын ажлыг эхлүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 63 | Ундны болон бэлчээрийн усны нөөцийн хайгуул, судалгаа явуулж, усан хангамжийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 64 | Бүсийн тулгуур төв хот-Дархан, Чойбалсан, Эрдэнэт болон Замын-Үүд, Цгааннуур, Алтанбулагийн чөлөөт бүсэд хийх гүний усны хангуул судалгааны ажлыг өргөжүүлж, усны тооллого явуулах замаар усны нөөцийн менежментийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 65 | Баг бүрт 2 худаг шинээр гаргах ажлыг 2 жилд хэрэгжүүлэх   | шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн тоо   | 1280         |
| 66 | Гар худаг гаргаж бэлчээр усжуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсан аймаг, сум, баг, иргэд, малчдыг урамшуулах тогтолцоог бий болгох  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 67 | Элсний нүүдлийг сааруулах чиглэлээр судалгааны ажлыг явуулж, уг арга хэмжээний талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлт гаргах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 68 | Ойжуулалтын хэмжээг тогтвортой нэмэгдүүлэх  | ойжуулах талбайн хэмжээ /ман.га/   | 10.0         |
| 69 | Орон нутгийн удирдлагын санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх  | орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын хэмжээ, /тэрбум, төг/  | 20.0         |
| 70 | Нутгийн удирдлагын эдийн засаг, санхүү, боловсон хүчний бие даасан байдалыг бэхжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 71 | Хөдөлгөөн соёлын үйлчилгээг сайжруулах, түүний материаллаг базаыг бэхжүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 72 | Аймгийн төвөөс болон хоорондоо 30 км-ээс дотогш байрлалтай сумдын эмнэлэг сургуулийнх нь үйл ажиллагааг хэвээр хадгалах нөхцөлтэйгээр засаг захиргааны нэгжийг өөрчлөх арга хэмжээ авч, хэмнэгдэх хөрөнгийг оновчтой төвлөрүүлж, тухайн орон-нутгийн иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чөлөөтүүлж эхлүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 73 | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс аймаг, сумын хөгжлийг дэмжихэд төвлөрүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 74 | Ашигт малтмалын хангуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс аймаг, сумын хөгжилд төвлөрүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 75 | Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийн тоог бууруулах  | - аймгийн төсөвт төвлөрүүлэх хувь<br>- сумын төсөвт төвлөрүүлэх хувь   | 20.0<br>10.0 |
| 76 | Ядуурлын бодит түвшнийг тогтоож, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх иргэдийн саналыг дэмжиж, ядуурлыг 2015 он гэхэд 2 дахин бууруулах   | - аймгийн төсөвт төвлөрүүлэх хувь<br>- сумын төсөвт төвлөрүүлэх хувь   | 25.0<br>25.0 |
| 77 | Ажлын бийр шинээр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшнийг бууруулах  | Дөрөв.Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого<br>нийт хүн амд ядууруудын эзлэх хувь<br>үйл ажиллагааны хэрэгжилтээр | 33.5         |
| 78 | Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгатаар олгож байгаа хөнгөлөлттэй зээл болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, хөрөнгө оруулалтыг дэмжих сангуудын хөрөнгийг төвлөрүүлэн, жижиг үйлдвэр, фермер, газар тариалангийн болон малчдын хөрөнгийг, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгатаар ашиглах, эзэлийн хүүг хөнгөлөх, баталгаа гаргах эрх зүйн орчныг бүрдүүлэх | ажилгүйдлийн түвшин / хувийр/<br>үйл ажиллагааны хэрэгжилтээр  | 3.3          |
| 79 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гадаадад ажиллах хүч гаргах, хөдөлмөрийн ажлуугүй ажиллагааны асуудлаарх бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |

|    |  |  |              |
|----|--|--|--------------|
| 80 | Аймаг, сумын төвд 50 мянгаас доошгүй ажлын байр бий болгох нөхцөлийг бүрдүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 81 | Сургуулийн өмнөх болон суурь боловсролын сургалтад хамрагчдын хүрээг өргөтгөх  | - сургуулийн өмнөх боловсролд хамрагчдагчдын хувь<br>- суурь боловсролд хамрагчдагчдын хувь                | 46.0<br>94.1 |
| 82 | Боловсролын системийн өөрчлөлт, шинэчлэлийн хүрээнд мэргэжлийн сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, эдийн засгийн бодит салбарт шаардагдах хөдөлмөрийн нөөц, хэрэгцээг судалсны үндсэн дээр бизнесийн салбарын мэргэжлийн холбоодын хөрөнгө оруулалтын өрлөөлөгчид мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг хөгжүүлэх цолг зорилгыг хэрэгжүүлэх.   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
|    | 1/ мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг хөрөнгөөр дэмжих;<br>2/ орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан, сургалтын стандартын шаардлага хангасан төрийн өмчийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг байгуулах.   |  |              |
|    | 3/ мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулж мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар хувийн хэвшлийнхээс гаргасан санаачилгыг дэмжих.  |  |              |
|    | 4/ мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг бүсийн хөгжлийн төвийг түшиглүүлэн гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн хүрээнд хөдөө аж ахуй, уул уурхай, барилга, дэд бүтцийн салбарт ажиллах мэргэжилтэй ажилчин бэлтгэх.  |  |              |
|    | 5/ их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд элсэгчдийн зохистой харьцааг бий болгох.  |  |              |
| 83 | Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн "Үдийн цай" хөтөлбөрт хамрагдсдын хүрээг өргөжүүлэх  | хөтөлбөрт хамрагдах анги   | 1-1ү анги    |
| 84 | Сургуулийн ихчээлийн болон дотуур байр, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барих, тоног төхөөрөмжөөр хангах   | - ашиглалтад орох сургуулийн суудлын тоо<br>- Улаанбаатар хотод ашиглалтад оруулах цэцэрлэгийн суудлын тоо | 5220<br>1500 |
| 85 | Хөнгий аймгийн Өндөрхаан хотод ерөнхий боловсролын сургуулийн барилга барих ажлыг эхлүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 86 | Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэхтэй холбогдуулан сургуулийн өмнөх боловсролын сургалтын стандартыг шинэчлэх, боловсронгуй болгох, сургууль-цэцэрлэгийн цогцолбор байгуулах, хөдөөгийн цэцэрлэг, зуны гэр цэцэрлэгийн хөгжилд дэвшил гаргах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |
| 87 | Шинжлэх ухаан, Технологийн арга хэмжээний зөрдлыг нэмэгдүүлэх, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ.<br>1/ шинжлэх ухаан, Технологийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, ургамал, биотехнологийн салбарыг тэргүүн эсэлжинд хөгжүүлэх.<br>2/ Ярдэм шинжилгээний лабораториудын тоног төхөөрөмжийг шинэчлэх, орчин үеийн оношилгооны багажаар хангах замаар судалгаа шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх.<br>3/ Шинжлэх ухааны ололт, шинэ бүтээгдэхүүн, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх. | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |              |



|     |  |  |                        |
|-----|--|--|------------------------|
| 88  | Биотехнологи, мэдээллийн технологийг хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх.   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 89  | "Манганы тунхаглал"-д нийцүүлэн эх, нялхсын эндэгдлийг 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн тоог 89-д, 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн тоог 19-д тус тус хургаж бууруулах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр<br>сумын эмнэлгийн тоо  | 3                      |
| 90  | Олон улсын жишигт нийцсэн сумын эмнэлэг байгуулж туршилтын журмаар ажиллуулах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 91  | Бүх сум, дүүргийн эмнэлгийг ЭХО болон оношилгоо, лабораторийн шинжилгээний техник хэрэгсэл, урвалж материаллаар үе шаттай хангах, 2006 онд хоронго оруулалтаар худалдан авсан 250-ЭХО аппаратыг үр дүнтэй ашиглах зорилгоор Улаанбаатар хотын аль нэг эмнэлэг дээр телемедицинский төв байгуулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 92  | Аймаг, бүсийн төв, дүүргийн нэгдсэн эмнэлгийг рентгенний аппарат, ходоодны дуран зэрэг оношилгооны техник хэрэгсэлээр хангах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр<br>- халдаарт өвчнийг эсэргүүцэх эм тарилга,<br>вакцины нөөцийн доод хягаар / хувиар/<br>- Дорхлажуулалтын вакцины хамрах хүрээ / хувиар/ | 20.0<br>94.0           |
| 93  | Халдаарт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины нөөцийг зохих түвшинд бүрдүүлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 94  | ДОХ /ХДХВ/-ын тархалтыг зогсоох чиглэлээр цогц арга хэмжээг ДЭМБ, НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 95  | Дорнод аймагт бүсийн оношилгооны эрүүл мэндийн загвар төвийг байгуулах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 96  | Яаралтай тусламжийн төвүүдийг байгуулах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 97  | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, улсын шигшээ багт хамрагдагсдын хүрээг өргөтгөх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 98  | "Залуу гэр бүл" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх   | шинэ гэр бүлийн тоо  | 12800                  |
| 99  | "Шинэ хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх   | шинээр төрөх хүүхдийн тоо  | 45500                  |
| 100 | "Хүүхдийн мөнгө" хөтөлбөрийн мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх замаар өрх гэр бүлд хоронго оруулалт хийх  | улсын төсвөөс сард нэг хүүхдэд олгох мөнгөний хэмжээ /төгрөгөөр/<br>Монгол Улсын хөгжлийн сангаас жилд нэг хүүхдэд олгох мөнгөний хэмжээ /төг/                         | 3000<br>100000<br>20.0 |
| 101 | Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 102 | Бүтцийн өөрчлөлттэй уялдуулж төрийн албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоож төсвийн өрөнхийлөн захирагч нь Урсгал зардалдаа зохицуулж тухайн ажилтны ажлын үр дүнг хөргөлөөн цалинжуулах журамд шилжих асуудлыг судалж шийдвэрлэх  | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 103 | Нийтийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх   | нэмэгдүүлэх хэмжээ /дахин/<br>/хувиар/   | 15.0<br>15.0           |
| 104 | Халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх   | хувиар/  | 1.3-1.5                |
| 105 | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 106 | Алдарт эхийн I, II зэргийн одонтой эхчүүдэд олгох тэтгэлгийг нас өлгөвөрлөхтэй олгох   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |
| 107 | Жирэмсний, амаржсаны болон өнчин хүүхэд асрамждаа авсны тэтгэмжийг өлгөвөрлөхтэй олгох   | үйл ажиллагааны хэрэгжилтээр   |                        |

|  |   |                              |
|--|---|------------------------------|
| 108  | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зориулсан дагуу тэтгэврийн даатгалын болон хэлэмжийн тогтолцоог шинэчилж, санхүүжилтийн механизмийг боловсронгуй болгох, нийгмийн даатгалын сангуудын бие даасан байдлыг хангаж чөлөөт үлдэгдлийн менежментийг сайжруулах, тэтгэврийн даатгалын сангийн үйл ажиллагаанд шинэчлэл хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх                  | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| <b>Тав.Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарыг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ</b> |   |                              |
| 109  | Гадаад харилцаа, батлан хамгаалах салбарт төрийн бодлогын уламжлалт чанарыг хадгалах  | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| 110  | Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ   | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| 111  | Мониторинг/ хийх<br>Жендерийн төлш байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох  | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| 112  | Авалга, хээл хахууль, хүнд сурталтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг чирэгдэлгүй болгох, хүнд суртлыг багасгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| 113  | Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын бүтцийг оновчтой тогтоож, яам, агентлагийн тогтвортой ажиллах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, захиргааны зардлыг бууруулах   | Эхний хагаст                 |
| 114  | Иргэдийн шалжилт бодолгооны бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох  | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| 115  | Төрийн байгууллагуудын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудад гүйцэтгүүлэх замаар нийгмийн тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэхэд иргэний нийгмийн төлөөллийн оролцоо оролцоог өргөтгөх   | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| 116  | Гадаад улс дахь Монгол Улсын Эгчлэн сайдын яам, дипломат төлөөлөгчийн газрын тоог нэмэгдүүлэх, ажиллах нөхцөл бололцоог сайжруулахын зэрэгцээ гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, суугаа орон, бус нутгаас хөрөнгө оруулалтыг татах, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх талаар хэрхэн ажиллах байгааг тэдгээрийн ажлыг үнэлэх нэг гол шалгуур болгох | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| 117  | Консулын албыг мэргэжүүлж бэхжүүлэх, гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн хууль ёсны эрх ашгийг хэрхэн хамгаалж байгааг дипломат албаны ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт болгох чиглэл баримтлах   | үйл ажиллагааны хэрэгжилтээр |
| 118  | Цагдаагийн байгууллагын ажиллах нөхцөл, бололцоог сайжруулах замаар гэмт хэрэг, түүний дотор малын хулгайтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх   | шинээр барих "кобан"-ы тоо   |

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

### Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг тус тус удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:**

1. Хуулийн 3 дугаар зүйлд туссан намд эвлэлдэн нэгдэх Монгол Улсын иргэний эрхийн талаархи зохицуулалтыг доорхи байдлаар тайлбарласуугай:

1.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан **"Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэн"** гэдэгт Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, 18 насанд хүрсэн этгээдийг ойлгоно.

1.2. Мөн зүйлийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасан **"Монгол Улсын иргэн зөвхөн нэг намын харьяалалтай байна"** гэдгийг улс төрийн намд эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэн нь хоёр буюу түүнээс дээш намд нэгэн зэрэг гишүүнээр бүртгэгдсэн байж болохгүй гэж ойлгоно. Нэг намд элсэж, гишүүнээр бүртгэгдсэн иргэн тухайн намын дүрэмд заасан журмын дагуу намын гишүүнчлэлээсээ татгалзаж, бүртгэлээс хасагдах өргөдөл гаргасан бол намаас гарсан гэж үзнэ. Өөр намын гишүүн болохын тулд урьд элссэн намын гишүүнээс гарсан байвал зохино.

1.3. Мөн зүйлийн 3.4-т заасан **"хуульд заасны дагуу төрийн зарим албан хаагч"** гэдэгт Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна.

2. Хуулийн 6 дугаар зүйлийн 5.2-т заасан **"Намын бүтэн болон товчилсон нэр нь байгууллага, аж ахуйн нэгж, болон бусад намын**

**нэртэй адил байхыг...хориглоно"** гэдгийг намын нэр нь хэлбэр, бичвэр, авиан дуудлагын хувьд Улсын Татварын Ерөнхий газрын дэргэдэх Улсын бүртгэлийн албаны Хуулийн этгээдийн нэрийн нэгдсэн жагсаалтанд бүртгэгдсэн бусад хуулийн этгээдийн нэртэй ижил байж болохгүй гэж ойлгоно.

3. Хуулийн 7 дугаар зүйлд намын гишүүний болон төрийн албан хаагчийн үүргийг заагласан зохицуулалтыг доорхи байдлаар тайлбарласуугай:

3.1. Энэ зүйлийн 7.1.-д заасан **"Намын зүгээс төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хутгалдан оролцохыг хориглоно"** гэдэгт төрийн байгууллага болон тэдгээрийн албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, ажил үүргээ гүйцэтгэхэд нь аливаа нам, түүний удирдлагын зүгээс үйл ажиллагааны чиглэл өгөх, зааж зааварлах, эсхүл төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас чөлөөлөх, албан тушаал бууруулах, өөр ажилд шилжүүлэх, ажилд шинээр томилоход хөндлөнгөөс оролцохгүй байх зэргийг хамааруулан ойлгоно.

3.2. Мөн зүйлийн 7.2.-т заасан **"төрийн жинхэнэ албан хаагч албан тушаалыгаа эрх мэдлийг аль нэгэн намын эрх ашигт нийцүүлэн ашиглахыг хориглоно"** гэдэгт төрийн тусгай болон захиргааны албан тушаалтан нь албан тушаалын үндсэн чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа аль нэг намын эрх ашигт нийцүүлэх зорилгоор ашиглах, энэ зорилгоор өөрийн албан тушаалын эрх мэдлийг хэтрүүлэх, гүйцэтгэвэл зохих үүргийг биелүүлэхгүй байх, Монгол улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож буй намаас зохион байгуулж байгаа сурталчилгааны ажилд эрхэлж буй ажил, албан тушаалын байдлыг ашиглан оролцохгүй байх зэргийг ойлгоно.

3.3. Мөн зүйлийн 7.3-т заасан **"улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч"** гэдэгт Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 5.1.4-т заасан төрийн тусгай захиргааны болон үйлчилгээний албан тушаалтан тус тус хамаарна.

3.4. Мөн зүйлийн 7.4-т заасан **"нам шашны байгууллагын үйл ажиллагаанд оролцохыг... хориглоно"** гэдгийг шашны байгууллагаас зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагаанд оролцох, эсхүл хориглох, зааж, зааварлах, өөрийн үзэл суртлын сурталчилгаанд ашиглахгүй байх эзрүүлэн ойлгоно.

Энэ заалтын **"боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаанд оролцохыг... хориглоно"** гэдэг нь боловсролын байгууллагын сургалтын агуулга, арга зүйг тодорхойлох, стандартыг тогтоох зэрэг ажиллагаанд оролцохгүй байхыг хэлнэ.

Харин намын удирдах албан тушаалтан, гишүүн нь шашин шүтэх, эс шүтэх, шашны байгууллага болон боловсролын байгууллагад удирдах буюу гүйцэтгэх ажилтан байхад энэ заалт хамаарахгүй.

4. Хуулийн 9 дүгээр зүйлд заасан намыг улсын бүртгэлд бүртгэх тухай зохицуулалтыг доорхи байдлаар тайлбарласуяй:

4.1. Энэ зүйлийн 9.1-д заасан **"... нам үүсгэн байгуулагдсан өдөр"** гэдгийг намыг үүсгэн байгуулах хурлаас намын дүрэм, хөтөлбөрийг баталж, нам байгуулах тухай шийдвэр гарсан өдрийг, мөн зүйл хэсгийн **"... бүртгэх байгууллагаас баталсан маягт"** гэдэгт Улсын Дээд шүүхээс баталсан өргөдлийн загварыг тус тус ойлгоно.

4.2. Нам нь Улсын Дээд шүүхэд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д зааснаас гадна энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.-т заасан баримт бичгийг дараахь байдлаар бүрдүүлнэ:

4.2.1. Энэ зүйлийн 9.3.1.-д зааснаар намыг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг Улсын

Дээд шүүхээс баталсан загварын дагуу гаргаж, намын дарга гарын үсэг зурсан байна.

4.2.2. Энэ зүйлийн 9.3.2.-т заасан намын нэр, бэлгэдэл, далбааны зургийг өргөдөлд хавсаргасан байх ба тэдгээрийн утга учрыг тайлбарласан байвал зохино. Намын нэр товчлогдох эсэх, товчлогдвол ямар хэлбэр, бичвэртэй байхыг тодорхой заана.

4.2.3. Энэ зүйлийн 9.3.3., 9.3.4.-т заасан намын дүрэм, хөтөлбөр нь энэ хуулийн 11, 12 дугаар зүйлүүдэд заасан шаардлагыг хангасан байна.

4.2.4. Энэ зүйлийн 9.3.5.-д заасан хууль ёсны хаягийг намын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа газрын хаягаар засаг захиргааны нэгж тодорхойлно.

4.2.5. Энэ зүйлийн 9.3.7.-д заасан 801-ээс доошгүй гишүүдээс бүрдсэн бүртгэлд намд элсэх өдөр хуанлийн тооллоор 18 насанд хүрсэн, өөр намын харьяалалгүй иргэд бүртгэгдсэн байх ба тэдгээрийн овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг зэрэг тусгагдсан байна.

4.2.6. Энэ зүйлийн 9.3.9.-д заасан намын хөрөнгийн мэдээнд үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн жагсаалт, тус намын гишүүн, талархан дэмжигч иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын жагсаалт зэргийг тусгасан байна.

Намыг улсын бүртгэлд бүртгэхээс өмнө тухайн намыг үүсгэн байгуулж буй удирдах албан тушаалтны нэр дээр банкны байгууллага түр данс нээсэн бол түүнийг тусгана.

5. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан **"намын Их Хурал"** гэдэгт тухайн намын дүрэмд нь удирдах дээд байгууллагыг хэрхэн нэрлэснээс үл хамааран намын дээд байгууллагыг ойлгоно.

6. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-д заасан **"Намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой**

**маргаан** гэдэгт намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо, намын бүх шатны байгууллага, хурлын үйл ажиллагаа, намын дүрэм, хөтөлбөрт өөрчлөлт оруулах, намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох, санхүүгийн эх үүсвэр, намын хөрөнгийн байдал, түүнийг захиран зарцуулах зэрэг намын дүрмийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой маргаанууд хамаарна.

Үндсэн хууль болон бусад хууль зөрчсөн намын үйл ажиллагаатай холбоотой маргааныг намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны маргаан гэж үзэхгүй.

7. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3-д заасан **"тороос үзүүлэх санхүүгийн дэмжлэг"** гэдэгт энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан Улсын Их Хуралд суудалтай намд олгох мөнгөн дэмжлэг болон суудлын тоогоор авах санхүүжилт хамаарна.

8. Хуулийн 19 дүгээр зүйлийн **"Улсын Их Хуралд суудалтай нам"** гэдэгт Улсын Их Хурлын ээлжит болон нөхөн сонгуульд нам буюу намын эвслээс дэвшсэн нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бөгөөд тухайн намын гишүүнчлэлийг хадгалж байгаа тохиолдолд түүнийг нэр дэвшүүлсэн, сонгуулийн саналын хуудсанд бичигдсэн нам буюу намуудын эвсэл хамаарна.

Нам буюу намын эвслээс дэвшсэн нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бөгөөд Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаандаа тухайн намаас гарч, өөр намын гишүүн болсон тохиолдолд түүний нэрийг дэвшүүлсэн намын Улсын Их Хурал дахь суудлын тоо хасагдаж, шинээр элссэн намд суудлын тоо нэмэгдэхгүй.

Аль нэг намын гишүүн намаасаа биш харин өөрөө бие дааж нэрээ дэвшүүлж, Улсын Их Хурлын

гишүүнээр сонгогдсон бөгөөд намын гишүүнчлэлээ хадгалсан, эсхүл өөр намын гишүүн болсон тохиолдолд түүний гишүүнчлэлээ хадгалж байгаа нам болон шинээр гишүүнээр элссэн намын алинд нь ч Улсын Их Хурал дахь суудлын тоо нэмэгдэхгүй.

Аль ч намын гишүүн биш, сонгуульд нэрээ бие даан дэвшүүлсэн нэр дэвшигч нь Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсоны дараа аль нэг намын гишүүн болсон бол тухайн намын Улсын Их Хурал дахь суудлын тоо нэмэгдэхгүй.

Улсын Их Хурлын ээлжит болон нөхөн сонгуульд оролцоогүй намыг Улсын Их Хурлын үйл ажиллагааны бүрэн эрхийн тухайн хугацаанд Улсын Их Хуралд суудалтай нам гэж үзэхгүй.

9. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан **"намын эрх барих дээд байгууллагын шийдвэр"** гэдэг нь тухайн намын эрх барих дээд байгууллагын ээлжит болон ээлжит бус хуралдаанаас намын дүрэмд заасны дагуу гаргасан баримт бичгийг хэлнэ.

10. Мөн зүйл, хэсгийн **"намыг улсын бүртгэлээс хасах"** тухай шийдвэрийг Улсын Дээд шүүх гаргана.

11. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу Улсын Дээд шүүх намыг тараах тухай шийдвэр гаргасан бол Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу татан буулгах комиссыг томилно.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**
**С.БАТДЭЛГЭР**
**ШҮҮГЧ**
**Д.ТУНГАЛАГ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэлэлцэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265058  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1.5